



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/623

Хэрлэн сум

“Шилдэг багш” нарыг шагнаж
урамшуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд зарлагдсан “ШИЛДЭГ БАГШ” болзолт уралдааны оролцогч нарыг шагнаж урамшуулахад 85,900,000 (наян таван сая есөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д, тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 07-ны
... дугаар захирамжийн хавсралт

“Шилдэг багш” болзолт уралдааны төсөв

№	Зардалын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	ЕБС 1-р байр	1	25,000,000	25,000,000
2	ЕБС 2-р байр	1	10,000,000	10,000,000
3	ЕБС 3-р байр	1	5,000,000	5,000,000
4	СӨБ 1-р байр	1	25,000,000	25,000,000
5	СӨБ 2-р байр	1	10,000,000	10,000,000
6	Оролцогчдын шагнал	20	500,000	10,000,000
7	Батламж	5	60,000	300,000
8	Өргөмжлөл	20	30,000	600,000
Нийт дүн				85,900,000